



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/93/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Цахим хуудас:
www.open.audit.mn
Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Аудитор С.Оргил
Утас: 77665858

Цахим хаяг: Shinjenmagadlahui.ezsh.audit@gmail.com

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

᠒᠐᠒᠕.᠐᠙.᠒᠑ № ᠑᠒
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН
СУМЫН 5 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ЖАРГАЛТОГТОХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 5-р цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд нийт 9 арга хэмжээнд төсвөөс 1,053,629.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэл 92.8 хувь буюу 978,681.2 мянган төгрөгийг зарцуулж, 70,668.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 5-р цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 7 үндсэн зорилтын 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 100 хувьтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	210,740,636.99	193,775,161.15
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	91,480,790.00	70,668,220.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	91,480,790.00	70,668,220.00
3121	Төгрөг	91,480,790.00	70,668,220.00
31211	Төрийн сангийн харилцах	91,480,790.00	70,668,220.00
35	БАРАА МАТЕРИАЛ	119,259,846.99	123,106,941.15
351	Түүхий эд материал		165,130.00
3513	Эм боох материал		165,130.00
354	Хангамжийн материал	119,259,846.99	122,941,811.15
3541	Бичиг хэргийн материал	1,623,920.00	3,796.920.00
3542	Аж ахуйн материал	93,099,536.99	86,616,845.15
3545	Барилгын засварын материал	24,408,990.00	32,416,990.00
3546	Хүнсний материал	127,400.00	111,056.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	78,461,446.36	80,658,865.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	78,461,446.36	80,658,865.18
392	Биет хөрөнгө	55,589,071.36	57,820,240.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	24,686,813.00	
39202	Хуримтлагдсан элэгдэл	-23,197,980.17	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	70,559,849.40	89,434,089.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-28,927,436.29	-37,499,847.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,663,011.90	25,780,041.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,882,521.48	-22,581,378.47
39217	Ном	2,687,335.00	2,687,335.00
393	Биет бус хөрөнгө	22,872,375.00	22,748,625.00
39301	Програм хангамж	1,417,500.00	1,417,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-961,125.00	-1,048,875.00
39303	Бусад биет бус хөрөнгө	22,416,000.00	22,416,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	289,202,083.35	274,344,026.33
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,426,420.00	800,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,426,420.00	800,000.00
413	Өглөг	4,426,420.00	800,000.00
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	1,426,420.00	
4136	Бусад өглөг	3,000,000.00	800,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг		800,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	3,000,000.00	
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	284,775,663.35	273,544,026.33
51	Засгийн газрын хувь оролцоо	284,775,663.35	273,544,026.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	80,024,772.00	80,024,772.00
51101	Өмч: - төрийн	80,024,772.00	80,024,772.00
512	Хуримтлагдсан үр дүн	186,893,934.24	175,662,297.22
5121	Өмнөх үеийн үр дүн	186,893,934.24	186,893,934.24
5122	Тайлант үеийн үр дүн		-11,231,637.02
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,856,957.11	17,856,957.11
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	289,202,083.35	274,344,026.33

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	812,492,200.00	985,185,670.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,467,000.00	23,142,270.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,467,000.00	23,142,270.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,000,000.00	105,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	105,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	8,467,000.00	23,037,270.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	801,025,200.00	962,043,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	743,702,200.00	833,273,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	743,702,200.00	833,273,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	57,323,000.00	128,769,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,323,000.00	128,769,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	723,477,854.89	995,121,256.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	723,477,854.89	995,121,256.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	704,811,384.53	990,841,456.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	464,665,116.00	650,618,980.00
210101	Үндсэн цалин	344,795,267.00	458,589,416.00
210102	Нэмэгдэл	97,038,781.00	158,600,514.00
210104	Урамшуулал	22,831,068.00	33,429,050.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,231,264.00	83,619,603.00
210201	Тэтгэврийн даатгал	42,437,806.74	57,486,619.88
210202	Тэтгэмжийн даатгал	4,734,780.37	6,629,922.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,944,628.47	3,352,261.62
210204	Ажилгүйдлийн даатгал	919,455.94	3,177,338.67
210205	Эрүүл мэндийн даатгал	9,194,592.48	13,073,460.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,833,829.64	97,989,809.00
210301	Гэрэл, цахилгаан	4,665,103.64	6,245,500.00
210302	Түлш, халаалт	39,353,936.00	78,949,202.00
210303	Цэвэр, бохир ус	7,814,790.00	12,795,107.00
2104	Хангамж, бараа материалын зардал		10,982,377.84
210408	Бараа материал акалсны зардал		10,982,377.84
2105	Нормативт зардал	83,881,430.00	86,516,811.00
210502	Хоол, хүнс	83,881,430.00	86,516,811.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,400,000.00	16,867,000.00
210604	Урсгал засвар	2,400,000.00	16,867,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	736,100.00	1,037,948.40
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	736,100.00	1,037,948.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,063,644.89	43,208,936.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,669,160.00	14,410,095.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,314,800.00	6,147,240.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,079,684.89	22,651,600.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,666,470.36	4,279,791.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	17,177,300.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,177,300.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		4,279,791.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		4,279,791.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,489,170.36	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,489,170.36	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	89,014,345.11	-9,935,586.37
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		1,296,050.65
225001	ҮНДСЭН ХӨРӨНГӨ ХУДАЛДСНЫ ГАРЗ		1,296,050.65
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		-1,296,050.65
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	89,014,345.11	-11,231,637.02

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	804,025,200.00	962,148,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,000,000.00	105,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,000,000.00	105,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,000,000.00	105,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	105,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	801,025,200.00	962,043,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	743,702,200.00	833,273,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	743,702,200.00	833,273,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	57,323,000.00	128,769,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,323,000.00	128,769,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	712,552,510.00	979,943,170.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	712,552,510.00	979,943,170.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	693,886,039.64	975,663,379.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	463,539,973.00	653,633,603.00
210101	Үндсэн цалин	323,077,921.00	453,751,890.00
210102	Нэмэгдэл	118,538,369.00	164,420,039.00
210104	Урамшуулал	21,923,683.00	35,461,674.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,929,987.00	82,031,400.00
210201	Тэтгэврийн даатгал	41,500,958.00	55,781,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,855,342.00	6,562,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,923,440.00	3,281,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	982,645.00	3,281,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,667,602.00	13,125,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,833,829.64	97,989,809.00
210301	Гэрэл, цахилгаан	5,022,444.57	6,245,500.00
210302	Түлш, халаалт	39,085,806.00	78,949,202.00
210303	Цэвэр, бохир ус	7,725,579.07	12,795,107.00
2105	Нормативт зардал	83,351,950.00	86,500,467.00
210502	Хоол, хүнс	83,351,950.00	86,500,467.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	26,500,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	26,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,466,600.00	2,381,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,466,600.00	2,381,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,763,700.00	26,626,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,799,700.00	18,193,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,964,000.00	8,433,000.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,666,470.36	4,279,791.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,177,300.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,177,300.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		4,279,791.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		4,279,791.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,489,170.36	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,489,170.36	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	91,472,690.00	-17,794,770.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		3,017,800.00
	Дотоод эх үүсвэрээр		3,017,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		3,017,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		-3,017,800.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	91,472,690.00	-20,812,570.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,100.00	91,480,790.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	91,480,790.00	70,668,220.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	80,024,772.00	17,856,957.11	186,893,934.24	284,775,663.35
9	Тайлант үеийн үр дүн			-11,231,637.02	-11,231,637.02
10	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	80,024,772.00	17,856,957.11	175,662,297.22	273,544,026.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харь-цуулалт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,053,629,100.00	978,681,179.00	74,947,921.00	92.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,053,629,100.00	978,681,179.00	74,947,921.00	92.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,053,629,100.00	978,681,179.00	74,947,921.00	92.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	714,803,800.00	653,633,603.00	61,170,197.00	91.44
210101	Үндсэн цалин	502,403,800.00	453,751,890.00	48,651,910.00	90.32
210102	Нэмэгдэл	185,977,900.00	164,420,039.00	21,557,861.00	88.41
210104	Урамшуулал	26,422,100.00	35,461,674.00	-9,039,574.00	134.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,384,800.00	82,031,400.00	2,353,400.00	97.21
210201	Тэтгэврийн даатгал	57,383,000.00	55,781,400.00	1,601,600.00	97.21
210202	Тэтгэмжийн даатгал	6,749,500.00	6,562,500.00	187,000.00	97.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,375,300.00	3,281,200.00	94,100.00	97.21
210204	Ажилгүйдлийн даатгал	3,375,300.00	3,281,200.00	94,100.00	97.21
210205	Эрүүл мэндийн даатгал	13,501,700.00	13,125,100.00	376,600.00	97.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,269,600.00	97,989,809.00	4,279,791.00	95.82
210301	Гэрэл, цахилгаан	12,342,600.00	6,245,500.00	6,097,100.00	50.6
210302	Түлш, халаалт	72,086,200.00	78,949,202.00	-6,863,002.00	109.52
210303	Цэвэр, бохир ус	17,840,800.00	12,795,107.00	5,045,693.00	71.72
2105	Нормативт зардал	91,787,800.00	86,500,467.00	5,287,333.00	94.24
210502	Хоол, хүнс	91,787,800.00	86,500,467.00	5,287,333.00	94.24
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,500,000.00	26,500,000.00		100
210604	Урсгал засвар	26,500,000.00	26,500,000.00		100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,381,600.00	2,381,600.00		100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,381,600.00	2,381,600.00		100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,501,500.00	29,644,300.00	1,857,200.00	94.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,068,500.00	21,211,300.00	1,857,200.00	91.95
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,433,000.00	8,433,000.00		100
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,053,629,100.00	957,868,609.00	95,760,491.00	90.91
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	833,273,800.00	833,273,800.00		100
131001	Улсын төсвөөс санхүүжих	833,273,800.00	833,273,800.00		100
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	128,769,600.00	124,489,809.00	4,279,791.00	96.68
132001	Орон нутгийн төсвөөс	128,769,600.00	124,489,809.00	4,279,791.00	96.68
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	91,585,700.00	105,000.00	91,480,700.00	0.11
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	105,000.00		100

1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	91,480,790.00		91,480,790.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		91,480,790.00	-91,480,790.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		70,668,220.00	-70,668,220.00	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30	29		
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	175	180		

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа залруулаагүй байна. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 3 зөрчил¹ илэрсэн бөгөөд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ. Аудитаар илэрсэн зөрчил нь материаллаг бус байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1 Тайлант онд 7 нэр төрлийн 6,051.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансны ахуйн материалын дансанд буруу бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 -т 'эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр, дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах' гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлээ.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон ахуйн хэрэгслийн орлого, зардлын бүртгэл тайлантай холбоотой.

Илрүүлэлт: 1. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/273 дугаар тушаалын хавсралтаар баталсан жагсаалтын дагуу эцэг, эх, асран хамгаалагчдаас хүлээн авсныг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгаагүй;

2. Нягтлан бодох бүртгэлийн цахим программыг өдөр тутмын ажил гүйлгээнд ашиглаагүй, бараа материалын зарлагын гүйлгээнүүдийг нэгтгэж сарын сүүлийн өдөр программд оруулсан, анхан шатны баримтыг программаар боловсруулаагүй гар аргаар хөтөлсөн байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4, 16 дугаар зүйлийн 16.5.7 дахь заалттай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Иймд аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, цаашид нягтлан бодох бүртгэлийн программд бараа материалын гүйлгээг тухай бүртгэх, анхан шатны баримтыг

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

программаар боловсруулах, хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг хүлээн авсан үед бараа материалын зохих дансанд орлогоор, сургалтын үйл ажиллагаанд тавьж олгосон тухай бүр зардлаар бүртгэж бараа материалын тайлан бэлтгэж үр дүнг санхүүгийн тайланд тусгаж, мэдээлэх арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "... албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасан тул зөвлөмжийн төлөвлөгөөг 2025.03.25-ны өдрийн дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлж ажиллана уу.

Энэхүү зөвлөмжийн төлөвлөгөөг ирүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасан ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохыг анхааруулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Буруу ангилан бүртгэсэнтэй холбоотой	1	6,051.8			1	6,051.8						
Бараа материал, , програмтай холбоотой	2	0					2	0				
Дүн	3	6,051.8			1	6,051.8	2	0				